



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 8 сарын 23 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,
эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээний
бэлэн байдлыг хангах чиглэлээр авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

1. Улаанбурхан өвчний лабораторийн шинжилгээгээр батлагдсан тохиолдол 2019-2024 онд бүртгэгдээгүй байсан бол 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдөр гадаад улсаас зөөвөрлөгдсөн халдвар лабораториор батлагдаж, дотоодын халдварын тоо нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар манай улсад улаанбурхан өвчний 12 тохиолдол лабораторийн шинжилгээгээр батлагдаад байна.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2024 оны 6 дугаар сард сармагчны цэцэг өвчний лабораторийн лабораторийн шинжилгээгээр батлагдсан 934 шинэ тохиолдол дэлхийн 26 оронд бүртгэгдэж, дөрвөн хүн нас барсан байна. Үүнээс Африкийн бүсэд 567, Америкийн бүсэд 175, Европын бүсэд 100, Номхон далайн баруун бүсэд 81, Зүүн өмнөд Азийн бүсэд 11 тохиолдол бүртгэгдсэн байна. Африкийн бүсэд 2024 оны 7-8 дугаар сард сармагчны цэцэг өвчний өвчлөл нэмэгдэхийн зэрэгцээ нутагшмал биш улс оронд халдварын тохиолдол нэмэгдэж байгаа тул Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдөр уг өвчнийг олон улсад хамаарах нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал хэмээн зарласан.

Хичээлийн шинэ жил эхэлж, улирлын шинжтэй хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, төвлөрөл үүсэх, томуугийн дэгдэлт идэвхижих зэргээр улсын хэмжээнд улаанбурхан өвчний халдварын тархалт нэмэгдэх, сармагчны цэцэг болон бусад халдварт өвчин зөөвөрлөгдөн ирэх өндөр эрсдэлтэй байгааг харгалзан халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын гишүүд, яам, агентлагийн дарга нар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

**Нэг. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайханд:**

1.1. Улаанбурхан, сармагчны цэцэг зэрэг халдварт өвчний олон улсын нөхцөл байдал, дотоодод тархах эрсдэл, бүс нутаг, хүн амд хэрхэн нөлөөлөх, халдварын давалгаа явагдах хугацаа, халдварт өртөх өндөр эрсдэлтэй хүн ам, нийгмийн бүлгийн талаар үндэслэл бүхий тооцоо, дүн шинжилгээ хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж Засгийн газар, Улсын онцгой комиссыг долоо

хоног тутам мэдээллээр хангах үүрэг бүхий мэргэжлийн эрдэмтэн, судлаачдын багийг байгуулан ажиллуулах,

1.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэглэлийн шаардлагатай нөөцийг тогтмол бүрдүүлэх, улаанбурхан өвчний дэгдэлт үүссэн тохиолд иргэдийг тусгаарлан эмчлэх эмнэлгийн ор дэлгэх төлөвлөгөөг гаргах, эмч, эмнэлгийн ажилтнуудын бэлэн байдлыг хангах, сургалтыг тогтмол явуулах,

1.3. Сармагчны цэцэг өвчний вакцин татан авах, нөөц бүрдүүлэх, улаанбурхан өвчний дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх,

Хоёр. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

2.1. Халдварт өвчний тохиолдол нэмэгдэж, нөхцөл байдал хүндэрсэн үед хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох, хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах, хяналт тавих үед шаардагдах журам, заавар зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан батлуулах, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах зэргээр шуурхай хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах үүрэг бүхий Улсын онцгой комиссын Шуурхай ажлын хэсэг, бүлэг байгуулан ажиллуулах, үйл ажиллагаанд хяналт тавих,

**Гурав. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан,
Боловсролын сайд П.Наранбаяр болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:**

3.1. Сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагуудад халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, дархлаажуулалтад хамрагдах чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх сургалтыг 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн тогтмол зохион байгуулах,

**Дөрөв. Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан,
ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзул болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт**

4.1. Улаанбурхан өвчний халдвар, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, дархлаажуулалтад хамрагдах талаар холбогдох зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах,


Тав. Цахим хөгжил, инноваци, харилцаа, холбооны сайд Ц.Баатархүү, Зам тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Х.Лхагвасүрэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Сүхболд, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал нарт:

5.1. Халдварын тархалт нэмэгдэж хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед хот дотор болон хот хооронд зорчих тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох, эрүүл мэндийн асуумж, судалгаа авах болон хилийн нэвтрэх цэгт зорчигч, тээврийн

хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих үед ашиглах цахим системийг 2024 оны 9 дүгээр сард багтаан бий болгож, бэлэн байдлыг хангах,

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын Ажлын албанд 14 хоног тутамд ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ДАРГА



С.АМАРСАЙХАН